

# МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2024 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



2024 ОНЫ 05 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДӨР, БААСАН ГАРАГ

## ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРОО

### ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

*Ta хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх  
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

**АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН  
АГУУЛГА**

*2024 оны 05 дугаар сарын 31-ний өдөр, Баасан гараг*

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны төвч тэмдэглэл:</i>	2 - 3
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	4 - 10

1. *Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль /Шинэчилсэн  
найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад  
хуулийн төслүүд /Засгийн газар 2024.05.03-ны өдөр өргөн  
мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/* 4 - 10

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы  
Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 05 дугаар сарын 31-ний өдөр  
/Баасан гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Б.Энх-Амгалан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 17 гишүүнээс 9 гишүүн хурэлцэн ирж, 52.9 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 19 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Д.Цогтбаатар;  
Эмнэлгийн чөлөөтэй: Г.Амартувшин, С.Батболд;  
Тасалсан: П.Анужин, Д.Ганбат.

**Нэг. Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслийүүд /Засгийн газар 2024.05.03-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Төрийн тусгай хамгаалалтын газрын дарга, бригадын генерал Л.Алтангэрэл, Төрийн тусгай хамгаалалтын газрын дэд дарга, хурандаа Д.Тэмүүлэн, Төрийн тусгай хамгаалалтын газрын Захиргааны удирдлагын газрын даргын албан үргийг түр орлон гүйцэтгэгч, хурандаа Х.Ууганбат, Төрийн тусгай хамгаалалтын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга, хошууч Э.Ариунаа, Төрийн тусгай хамгаалалтын газрын Санхүүгийн хэлтсийн дарга, хошууч Ч.Бат-Очир нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ж.Чимгээ, референт Б.Гандиймаа нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Сэргэлэнгийн тавьсан асуултад Төрийн тусгай хамгаалалтын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга, хошууч Э.Ариунаа хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-т заасны дагуу Төрийн тусгай хамгаалалтын тухай /Шинэчилсэн найруулга/ хуулийн төслийн талаар гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

**Б.Энх-Амгалан:** 1.Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалангийн гаргасан, Төслийн 6 дугаар зүйлийн 6.5 дахь хэсгийн “албан тушаалтныг” гэснийг “албан тушаалтан, эсхүл төр, нийгмийн зүтгэлтнийг” гэж өөрчлөх гэсэн саналыг дахин санал хураалт явуулахыг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 2  
Бүгд: 10

80.0 хувиар буюу гуравны хоёроор санал дэмжигдлээ.

**Б.Энх-Амгалан:** 1. Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалангийн гаргасан, Төслийн 6 дугаар зүйлийн 6.5 дахь хэсгийн “албан тушаалтныг” гэснийг “албан тушаалтан, эсхүл төр, нийгмийн зүтгэлтнийг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 1  
Бүгд: 11  
90.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Гүйцэтгэх ажлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төмөр замын тээврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Радио долгионы тухай хуульд нэмэлт оруулах тухай, Геодези, зураг зүйн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрдэнэсийн сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын төрийн ордны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Төрийн тусгай хамгаалалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 10 цаг 35 минутад хэлэлцэж дуусав.*

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 17 минут үргэлжилж, 17 гишүүнээс 12 гишүүн хүрэлцэн ирж, 70.6 хувийн ирцүтэйгээр 10 цаг 36 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ  
ДАРГА

Б.ЭНХ-АМГАЛАН

**Тэмдэглэл хөтөлсон:**

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ  
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 05 дугаар сарын 31-ний өдөр,  
Баасан гараг  
Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар”  
танхим  
10 цаг 19 минут

## БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**Б.Энх-Амгалан:** 2024 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 11.6-д заасны дагуу ирцийг танилцуулья.

Бямбасүрэнгийн Энх-Амгалан ирсэн, Норовын Алтанхуяг ирсэн, Ганибалын Амартувшин өвчтэй, Пүрэв-Очирыг Анужин гишүүнийг дуудаарай. Хавдисламын Баделхан гишүүн ирсэн, Энхтайваны Бат-Амгалан гишүүн ирсэн, Баагаагийн Баттөмөр гишүүн ирсэн, Бадмаанямбуунийн Бат-Эрдэнэ гишүүн ирж байгаа. Тийм ээ. Дуудаарай. Сүхбаатарын Батболд гишүүн өвчтэй, Дашдондогийн Ганбат гишүүн чөлөөтэй, Борхүүгийн Дэлгэрсайхан гишүүн

томилолттой, Нанзадын Наранбаатар гишүүн ирсэн, Салдангийн Одонтуяа гишүүн ирсэн, Цэдэвийн Сэргэлэн гишүүн ирсэн, Дамдины Цогтбаатар гишүүн чөлөөтэй, Нямаагийн Энхболд гишүүн ирсэн, Жаргалтулгын Эрдэнэбат гишүүн ирсэн байна.

Гишүүдийн ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг Та бүхэнд танилцуулья.

Хэлэлцэх асуудал нэг асуудал байна.

Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүд Засгийн газар 2024 оны 05 сарын 03-ны өдөр өргөн мэдүүлсэн.

Эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

Хэлэлцэх асуудлын талаар саналтай гишүүн байна уу? Алга байна.  
/алх цохив/

Хэлэлцэх асуудалдаа оръё.

**Нэг.Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн  
төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүд  
/Засгийн газар 2024.05.03-ны өдөр өргөн мэдүүлсэн,  
эцсийн хэлэлцүүлэг/**

Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулья.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулья.

Төрийн тусгай хамгаалалтын газрын дарга, бригадын генерал Лхамсүрэнгийн Алтангэрэл, Төрийн тусгай хамгаалалтын газрын дэд дарга, хурандаа Долгорсүрэнгийн Тэмүүлэн, Төрийн тусгай хамгаалалтын газрын Захиргааны удирдлагын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч хурандаа Хурцын Ууганбат, Төрийн тусгай хамгаалалтын газрын Хууль эрх зүйн хэлтсийн дарга хошууч Эрдэнэдашийн Ариунаа, Төрийн тусгай хамгаалалтын газрын Санхүүгийн хэлтсийн дарга хошууч Чойжамцын Бат-Очир гэсэн хүмүүс оролцож байна.

Хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулгыг Байнгын хорооны гишүүдэд урьдчилан тараасан байгаа.

Танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Б.Энх-Амгалан миний бие танилцуулна. /алх цохив/

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 05 сарын 03-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын 2024 оны 05 сарын 28-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Байнгын хорооноос чуулганы нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж, олонхын дэмжлэг авсан зарчмын зөрүүтэй саналуудыг Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийн холбогдох хэсэг, заалтад нэмэлт тусгаснаас гадна төслийн агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр дэс дараалал, бүтцийн шинжтэй засварыг хийж, хууль зүйн техникийн талаас нь хянаж, зохих засвар өөрчлөлтийг хийсэн эцсийн хувилбарыг Та бүхэнд тараасан болно.

Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Гүйцэтгэх ажлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төмөр замын тээврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Радио долгионы тухай хуульд нэмэлт оруулах тухай, Геодези, зураг зүйн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрдэнэсийн сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Сонгуулийн автоматжуулсан системийн хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын төрийн ордны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл болон эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх танилцуулгыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Хуулийн төслийн танилцуулгыг  
Та бүхэнд танилцууллаа.

Хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулгатай холбогдуулан асуулт асуух гишүүд байвал нэрээ өгнө үү.

Ц.Сэргэлэн гишүүнээр тасалья.

Ц.Сэргэлэн гишүүн асуултаа асууя.

Ажлын хэсгийнхэн хүмүүсээ цуглуулаарай. Яагаад гэвэл энэ дээр санал хураалт явагдах учраас. Гуравны хоёроор санал хураалт явагдана шүү.

Ц.Сэргэлэн гишүүний микрофоныг өгье.

**Ц.Сэргэлэн:** Би хуулийн төслийн эцсийн найруулгыг үзээд, уншаад сууж байна л даа.

Тэгээд энэ дээр нэг юм асууя гэж бодлоо.

Амьдрал дээр бас гарсан асуудал л даа.

Монгол Улсын Ерөнхийлөгчөөр ажиллаж байгаад сонгуулийн дараа ажлаа өгчихсөн байсан Н.Энхбаяр Ерөнхийлөгчийг Авлигатай тэмцэх газраас баривчлах ажиллагаа явагдсан.

Тэгээд үүнийг орон даяар телевизээр нээлттэй мэдээллийг дамжуулсан шүү дээ.

Тэгээд миний ойлгосноор төрийн тусгай хамгаалалтад байсан хүн яг тухайн үед, яг баривчлах ажиллагааны үед, эхний үед. Дараа нь одоо манайхны ярьдгаар хөл гарыг нь гозолзуулсан гэж яриад байдаг тухай бол биш. Тэрний өмнөх орой болсон процесс.

Гэтэл Н.Энхбаяр Ерөнхийлөгчийг төрийн тусгай хамгаалалтын албаны ажилтан хамгаалаад явж байсан. Машиндаа.

Гэтэл Авлигатай тэмцэх газар буюу төрийн тусгай бас албаны ажилтнууд очоод саатуулах гэж оролдсон. Ингээд хоорондоо тэд нарын хооронд зөрчил үүссэн.

Энэ үед хоёулаа л хуулийн дагуу чиг үүргээ хэрэгжүүлсэн. Төрийн тусгай хоёр алба хоорондоо.

Гэтэл хоорондоо ойлголцоогүй.

Нэг нь хамгаалалтад байж байсан субъект. Нөгөөдөх нь болохоор төрийн тусгай алба хуулийн дагуу үүргээ гүйцэтгээд хамгаалалтад байгаа объектыг саатуулах гээд очсон.

Би бол тэр төрийн тусгай албаны ажилтныг өмөөрдөг хүн. Дараа нь тэр хүнийг буруутгаад байсан юм.

Хуулиар хүлээсэн үүргээ биелүүлж явсан төрийн тусгай албаны ажилтан. Тэр хамгаалуулж байсан субъект хэн байх нь хамаагүй. Үүргээ биелүүлж явсан хүн.

Хэрвээ цаашдаа яг ийм нөхцөл байдал тулгарвал яахыг зохицуулсан эрх зүйн акт тухайн үед байгаагүй юм шиг байгаа юм.

Би үүнийг юу гэж ойлгож харамсаж байсан бэ гэхээр төрийн тусгай байгууллагууд хоорондоо харилцан ажиллагааныхаа журмаар иймэрхүү үед ингэнэ тэгнэ гэдгээ зохицолдоод, эсвэл яг саяынх шиг тийм процесс үүссэн тохиолдолд бусад хууль хяналтын байгууллагуудтайгаа ярилцаад тохиролцоод ингээд бас эвтэйхэн зохицуулах тийм боломж байгаагүй юм болов уу гэж би тухайн үед бодож байсан юм.

Тэгтэл энэ хууль дээр зохицуулсан харилцаа нь болохоор яг тэр харилцааг зохицуулаагүй байна. Энд өрөөсөө үг, өгүүлбэр алга.

Ганцхан төрийн тусгай хамгаалалтыг зогцох процессын тухай энд орчихсон явж байна.

Гэтэл тэр нь яаж орсон бэ гэхээр тэр баривчлах процессын тухай биш шүүхээр эцэслэж гэм буруутай нь тогтоогдсон, ял эдэлж байгаа гэх мэтчилэн ийм үед зогсоон гээд заачихсан.

Миний хэлээд байгаа тэр тухайн үеийн процесс бол тэр хүнийг гэм буруутай гэдгийг тогтоогоогүй байсан процесс шүү.

Тэгэхээр энэ үед одоо яах болж байна гэдгийг л би зүгээр гэнэтхэн сая би үүнийг уншчихаад толгойд орж ирээд асууж байгаа юм шүү. Та бүхэн минь амьдрал дээр тохиолдож болзошгүй учраас гаргалгаагаа сайн бодоорой л гэж хэлэх гээд байгаа юм шүү.

Адилхан одоо бас төрийн тусгай албандаа зүтгэж явсан хүний хувьд сэтгэл, бас санаа зовдог юм байдаг юм.

**Б.Энх-Амгалан:** Хэн хариулах вэ?

4 номерын микрофон хариулья.

Тусгай хамгаалалтад байж байгаад яасан хоёр жишээ байна шүү.

Ерөнхий сайдын нэг жишээ байна, Ерөнхийлөгчийн нэг жишээ байна.

4 номерын микрофон хариулья. Микрофон дээр нэрээ хэлээд албан тушаалаа хэлээд тэгээд хариулья.

**Л.Алтангэрэл:** Та бүхэнд өнөө өглөөний мэндийг хүргээ.

Саяын Ц.Сэргэлэн гишүүний асуусан асуултад манай Хууль эрх зүйн хэлтсийн дарга Э.Ариунаа тодорхой хариулна.

**Б.Энх-Амгалан:** 3 номерын микрофоныг өгье. 3 номерын микрофон асуултад хариулья.

Төрийн тусгай хамгаалалтын газрын Хууль эрх зүйн хэлтсийн дарга хошууч Эрдэнэдашийн Ариунаа. Тийм биз? 3 номер хариулья. 3 номерын микрофоныг өгье. 5 номерыг өгөөд байна. 3 номерыг өгье.

**Э.Ариунаа:** Ц.Сэргэлэн гишүүний асуултад хариулья.

Ярьсан жишээнүүдийн яг тухайн цаг үед энэ асуудлыг зохицуулсан зохицуулалт байгаагүй.

Үүний дараа хуулийн одоогийн хүчин төгөлдөр үлчилж байгаа Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн 6 дугаар зүйлд энэ зохицуулалт орж ирсэн. Орж ирээд буюу баривчлах, төрийн тусгай хамгаалалтад байгаа иргэн, албан тушаалтан гэмт хэрэгт холбогдон цагдан хорих, таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан, эсхүл яллагдагчаар цаашид хорьж мөрдөх зайлшгүй шаардлагатай гэж үзэн шүүгчийн захирамж гарсан тохиолдолд цагдан хорих, таслан сэргийлэх арга хэмжээ үргэлжлэх хугацаанд төрийн тусгай хамгаалалт түдгэлзэнэ гэдэг агуулга бүхий зохицуулалт яг тэр нэрлэсэн тохиолдлын дараа хуульд нэмэлт, өөрчлөлт орсон байдаг.

Одоо бидний боловсруулж танилцуулж байгаа хуулийн төсөл дээр саяын гишүүний нэрлэдэг төрийн тусгай хамгаалалт түр зогсох гэдэг хүрээнд энэ зохицуулалт, агуулга орчихсон байгаа гэж үзэж байгаа.

Өөрөөр хэлэх юм бол холбогдох эрх бүхий байгууллагууд тухайн хууль хэрэгжүүлэх үйл ажиллагаагаа явуулахдаа байгууллагад мэдэгдсэнээр тухайн үйл ажиллагаа хуулийн дагуу явагдаж байна гэж мэдэгдсэний дараа хамгаалалт түдгэлзэх ийм асуудал, зохицуулалт орсон байгаа. Хуульд.

**Б.Энх-Амгалан:** Гишүүд асуулт асууж, хариулт авч.

Ц.Сэргэлэн гишүүн тодруулъя. Ц.Сэргэлэн гишүүний микрофоныг өгье.

**Ц.Сэргэлэн:** Яах вэ, энэ төрийн тусгай хамгаалалт түр зогсох. Түр юу байх вэ. Зогсох энэ харилцаанд орсон гэж хариулж байна. Та.

Зүгээр би уншаад, энд яг тэрийг миний саяын хэлсэн тэр кэйс гэдэг юм уу, тэр тохиолдолд хэрхэх тухай эрх зүйн зохицуулалт арай л бүрхэг байх шиг санагдаад байна шүү. Яах вэ зохицуулах боломжууд байгаа гэж би бодож байна.

Энэ бол тухай тухайн хариуцсан төрийн тусгай байгууллагуудтайгаа урьдчилж харилцан ажиллагааныхаа журмаар зохицуулалт хийгээд, эсвэл янз бүрийн байдлаар дээд шатных нь байгууллагатай байдаг юм уу, прокурор байдаг юм уу.

Ийм байгууллагуудтай харьцах журмаар асуудлыг зохицуулаад явах ийм боломж байдаг л болов уу гэж би бодоод байгаа юм.

Гэхдээ энэ хууль дээр яг үнэхээр та нар сайн үзээрэй. Яг миний саяын хэлсэн юу бол тийм маш тодорхой ороогүй байна шүү.

**Б.Энх-Амгалан:** Ц.Сэргэлэн гишүүний асуултад хариулаадахъя.

Хуулийн 6.2.5 дээр Монгол Улсын Ерөнхийлөгчийн албан тушаал хашиж байсан “иргэн”. “Хүн” гэдгийг иргэн гэж авсан. “Иргэн, хуулийн этгээд” гэж явдаг учраас.

Бүрэн эрхийнх нь хугацаа дууссанаас эхлэн 3 жил.

Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдын албан тушаал хашиж байсан иргэн бүрэн эрхийнх нь хугацаа дууссанаас эхлэн 2 жилийн хугацаанд төрийн хамгаалалтад байна гэж байгаа юм.

Төрийн хамгаалалтад байж байгаа төрийн тусгай хамгаалалт түр зогсох гэдэг саяын энэ 9.1 дүгээр заалт үйлчлэхээс гадна 9.2 үйлчилнэ.

9.2 дээр юу байна гэхээр “хамгаалуулагч” нь гэмт хэрэг нь гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдож шүүхийн шийтгэх хүчин төгөлдөр тогтоол гарснаас хойш гэж байгаа шүү.

Хэрвээ шүүхийн гэмт хэрэгт нотлогдоод шүүхийн шийдвэр гараагүй бол тэр хүн хамгаалалтдаа байна гэсэн санаа энэ дээр байгаа юм шүү. Тийм.

Шүүхийн шийдвэрээр нотлогдож, шүүхийн шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болсноос хойш хамгаалалт буух болохоос биш зүгээр шүүхийн шийдвэр гараагүй байхад прокурорын зөвшөөрлөөр ирж хамгаалалт буулгаж баривчлах ийм асуудал байхгүй.

Энэ бол 9.2 шүү. Үүнийг тэгж ойлгож байгаа биз бид нар. Ингэж ойлгож байгаа шүү.

Ингээд протоколд тэмдэглэчихье.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Ирцэд Б.Бат-Эрдэнэ гишүүн орсон байна, Н.Наранбаатар гишүүн орсон байна.

Хуулийн төслийн танилцуулгатай холбогдуулан гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42.2-т холбогдох Байнгын хороо эцсийн хэлэлцүүлэг явуулахдаа дараах

тохиолдолд санал хураалт явуулж болно гэж.

Мөн хэсгийн 42.2.3-д заасан нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хураалт дэмжигдсэн боловч уг саналаар Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь дахин санал хураалгах шаардлагатай гэж үзсэн тохиолдолд санал хураалт явуулахаар заасан.

Би нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр дэмжигдсэн Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн 6.5 дахь хэсгийн “албан тушаалтны” гэснийг “албан тушаалтан, эсхүл төр, нийгмийн зүтгэлтэн” гэж өөрчлөх санал гаргаж байгаа юм.

Ингээд дахин санал хураалт явуулахыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулья. Энд гуравны хоёроор босох учраас гишүүдийг саналаа өгөхийг хүсье.

Санал хураалт. /алх цохив/

Санал хураалтад 10 гишүүн оролцож, 8 гишүүн дэмжиж, 80.0 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

Одоо үндсэн санал хураалт явуулья.

Би дэмжиж санал өгсөн. Намайг протоколд тэмдэглэчхээрэй. Энэ юу ажиллаагүй байна.

Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь дахин санал хураалт явуулах саналыг дэмжсэн тул Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн төслийн 6 дугаар зүйлийн 6.5 дахь хэсгийн “албан

тушаалтан” гэснийг “албан тушаалтан, эсхүл төр, нийгмийн зүтгэлтнийг” гэж өөрчлөх саналаар санал хураалт явуулья.

Санал хураалт явуулья. /алх цохив/

Санал хураалтын дүнг танилцуулья.

Санал хураалтад 11 гишүүн оролцож, 10 гишүүн дэмжиж, 90.9 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

Гишүүддээ баярлалаа.

Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Гүйцэтгэх ажлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төмөр замын тээврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Радио долгионы тухай хуульд нэмэлт оруулах тухай, Геодези, зураг зүйн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрдэнэсийн сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Монгол Улсын

Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын төрийн ордны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Төрийн тусгай хамгаалалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг хийж дууслаа. /алх цохив/

Хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны танилцуулгыг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ сайд танилцуулья.

Байнгын хорооны өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

Хуралдаанд идэвхтэй оролцсон Улсын Их Хурлын гишүүдэд болон ажлын хэсэгт баярлалаа. Хуралдаан өндөрлөлөө.

Хуралдаан 17 минут үргэлжилж, 10 цаг 36 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,  
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

**Ц.АЛТАН-ОД**